



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 9/64

Аргатай

1 дүгээр багийн усан хангамжийг
нэмэгдүүлэх үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "1 дүгээр багийн усан хангамжийг нэмэгдүүлэх" 2 цооногийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны даргад: Б.Будням (Арга зүйч)

Нарийн бичгийн даргад: Г.Лувсандагва (Өвийн ажилтан)

Гишүүн: Д.Эрдэнэбат (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга)

2. Тендер шалгаруулалтыг хууль дүрмийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Будням)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг бүрдүүлж цахим системд архивын нэгж үүсгэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Лувсандагва)-д үүрэг болгосугай.

ДАРГА



О.УУГАНБААТАР